



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 799

Улаанбаатар хот

### Төрийн өмчийг эзэмшүүлж, бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 5 нэрийн, нийт 1,900,544,957.00 (нэг тэрбум есөн зуун сая таван зуун дөчин дөрвөн мянга есөн зуун тавин долоон) төгрөгийн үнэ бүхий лабораторийн цогцолбор барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораториид эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бурийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
123007258  
37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн  
дугаар тогтоорын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЭЙН САЙДЫН БАГЦ-ААР  
БАРЬСАН, ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ /БАРИЛГА БАЙГУУЛАМЖ/**

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Лабораторийн конторын барилга	Контор, лабораторийн зориулалттай, бага төвөгшилтэй зорьгүй, 2 давхар 2358 м3 эзэлхүүнтэй, 720 м2 талбайтай барилга,	1,127,612,391.00	2022.12.22	БА-286/2022	
2	Амь сорил био агуулгүйн лабораторийн барилга	Контор, лабораторийн зориулалттай, бага төвөгшилтэй зорьгүй, 2 давхар 2358 м3 эзэлхүүнтэй, 720 м2 талбайтай барилга,	567,764,987.00	2022.12.22	БА-286/2022	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо Биокомбинатын хашаанд Мал эмнэлгийн эмийн сорилт
3	Гадна талбай тохижилт	Гадна талбай, сүүдрэвчийн хамт тохижилт	36,244,418.00	2022.12.22	БА-286/2022	баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ
4	Барилгын гаднах инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламжийн бага төвөгшилтэй, МЭЭСБУЛ-ын барилгын гадна шугам сүлжээний угсралт	78,598,250.00	2020.08.17	ШС-001/2022	
5	Пойлуурь узель	Барилга байгууламжийн бага төвөгшилтэй, МЭЭСБУЛ-ын барилгын гадна шугам сүлжээний угсралт	90,324,911.00	2022.01.25	ШС-001/2022	
			1,900,544,957.00			

НИЙТ ДҮН

<p>(нэг тэрбум есөн зүйн сая таван зуун дөчин дөрвөн мянга есөн зүйн тавин долгоон төгрөг)</p>	

